



МИК ХОЛДИНГ ХК

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2021 оны 11 сарын 03 өдөр

№ 21/48

Улаанбаатар хот

### *Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг түр томилох тухай*

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хорооны 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлын 19 дугаартай дүгнэлт, Монгол Улсын Хөгжлийн банкны 2021 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 2/733 тоот албан бичгийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах ердийн гишүүн Бат-Ирээдүйн Анарыг 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөр Төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Энэ тогтоолын 1-т заасантай холбогдуулан чөлөөлөгдсөн ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдээр Монгол Улсын Хөгжлийн банкны Бизнес хөгжил хариуцсан дэд захирал Сэдваанчигийн Цэрэндашийг 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн Б.Анарын хэрэгжээгүй үлдсэн бүрэн эрхийн хугацаагаар түр томилсугай.
3. С.Цэрэндаш нь энэ тогтоолын 2-т заасан бүрэн эрхийн хугацаанд ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлж, Б.Анарын гишүүнчлэл бүхий Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хорооны бүрэлдэхүүнд орж ажиллахыг дурдсугай.
4. С.Цэрэндаштай “Нууц үл задруулах гэрээ” байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (М.Мөнхбаатар)-д даалгасугай.
5. С.Цэрэндашийн бүрэн эрхийн хугацаа хэрэгжиж эхэлсэн өдрөөс эхлэн холбогдох журмын дагуу батлагдсан төсвийн хүрээнд цалин олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д даалгасугай.
6. Энэ тогтоолд зааснаар Төлөөлөн удирдах зөвлөл, түүний дэргэдэх холбогдох хорооны бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтийн талаар зохих хууль тогтоомжид заасан журмын дагуу хувьцаа эзэмшигч болон олон нийтэд мэдээлэл хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба (Г.Саруул)-нд даалгасугай.
7. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх, шагнал урамшууллын хороо (Ч.Хашчулуун)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



М.МӨНХБААТАР

★★★★